


**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2024 он

Улаанбаатар хот

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх			
	<p>1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх; Шалгуур үзүүлэлт: - Баримтжуулсан байх, -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо), -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх</p>	<p>Жилдээ</p>	<p>МУ-ын Ерөнхий Сайдын 2024 оны 14 дүгээр захирамжаар батлагдсан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын цахим хуудсаа шинэчилсэн. Цахим хуудасны ил тод буланд Авлигатай тэмцэх үйл ажиллагааны буланд Авлигатай тэмцэх төлөвлөгөө, тайлан, урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээлэл, Зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар, хувийн ашиг сонирхлыг урьдчилан мэдүүлэг хянасан дүгнэлт гэсэн дэд цэс үүсгэсэн. Дэд цэс тус бүрт хамаарах мэдээ, мэдээллийг шинэчлэн тухай бүр оруулан ажилласан. Мэдүүлэг гаргагчид зориулсан гарын авлага, Нэгдье-110 зурагт хуудас, Ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх гарын авлага, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Мэдүүлэг гаргагчид зориулсан гарын авлага зэрэг мэдээллийг байгууллагын цахим хуудасны урьдчилан сэргийлэх, зөвлөмж мэдээлэл буланд байршуулсан. Засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан авлигын эсрэг үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог ханган хүнд суртал, чирэгдлийг бууруулах авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан зурагт хуудас, мэдээллийг байгууллагын цахим хуудас болон нийгмийн сүлжээнд байршуулж мэдээлсэн. Мөн байгууллагын олон нийтийн сүлжээ /фэйсбүүк/-гээр дамжуулан авлигын эсрэг үйл ажиллагаа сурталчилсан. Тус газрын хэмжээнд нийт 21 видео, танилцуулга, нийтлэл, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна. Мөн олон нийтийн сүлжээ /фэйсбүүк/-т 85 удаа зурагт хуудас болон мэдээ, мэдээлэл оруулсан байна.</p> <p>21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэдээллийн самбар болон олон нийтийн сүлжээгээр Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн контентийг байршуулсан. Авлигын эсрэг агуулгатай зурагт хуудас, нугалбар зэргийг 20000 гаруй иргэдэд хүргэн ажилласан.</p> <p>“Нэгдье” сэдэвт зурагт хуудсыг албан хаагчдын өрөө болон иргэд олон нийт үйлчлэх хэсэгт байршуулсан. Нийслэлийн ГЗБА болон аймгийн ГХБХБГ-ууд өөрсдийн нөөц бололцоогоор гарын авлага, тараах материал хэвлүүлэн сурталчилах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>



1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг харьяа байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;

Шалгуур үзүүлэлт: -Хоёроос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; - Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх

Жилдээ

21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга болон газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчдыг хамруулсан сургалтыг 2024.04.29-ны өдөр, кадастрын асуудал хариуцсан албан хаагчдын сургалтыг 2024.05.29, 30-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Дээрх 2 сургалтаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар С.Баярцэцэг Авлигын эсрэг хууль, Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, Шударга байдлын үнэлгээ-2022,2023, Авлигын хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зохион байгуулсан ажил, Төрийн үйлчилгээний талаар иргэд мэдээлэл өгөх зорилготой 1927 төрийн, төрийн өмчийн байгууллагыг нэгтгэсэн “Товш” аппликэйшнийг татах заавар зэрэг сэдвүүдээр танилцуулга хийж мэдээлэл өгсөн. Шударга байдлын үнэлгээгээ газрын алба сүүлийн жилүүдэд сүүлийн байр эзлэж байгаатай холбогдуулан газрын албаны үйл ажиллагааг цахимжуулах, хүний оролцоог багасгах, иргэн, аж ахуйн нэгжийг газрын албан дээр ирүүлэхгүй байх чиглэлээр анхаарч ажиллаж байна. Мөн нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд тус газрын 2024 оны 1/1357 дугаартай албан бичиг хүргүүлээд байна.



<p>1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;</p> <p>Шалгуур үзүүлэлт: - Мэдээллийг сар бүр шинэчлэх; Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх</p>	<p>Жилдээ</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг байгууллагын үүдэнд байршуулж иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Байгууллагын мэдээллийн самбарыг 2024 онд шинэчилсэн бөгөөд Авлигын эсрэг, үйл ажиллагаа хэсэгт “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” зураг хуудас хийж байршуулсан. Мөн байгууллагын Бүтэц зохион байгуулалт, Танилцуулга, Хууль эрх зүй, Төсөв санхүү, Мэдээлэл лавлагаа, Өргөдөл гомдол, Цахим үйлчилгээ, Ил тод байдал, Зөвлөмж, Сурталчилгаа гэсэн холбогдох мэдээллийг байршуулан тухай бүр шинэчилж байна. Шинэчлэн гаргасан мэдээллийн самбарт гомдол, мэдээлэл хүлээн авах утас 110, Авлигатай тэмцэх газрын цахим хуудсны хаяг зэрэг мэдээллийг байршуулсан.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар 3 удаа бүрэн шинэчилсэн. Төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд авлигын эсрэг урьдчилан сэргийлэх “Шударга ёс хөгжил дэвшилд-110” мэдээллийн самбарыг нийслэл, 9 дүүргийн Газар зохион байгуулалтын албанд байршуулсан бөгөөд Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны цахим хуудасны мэдээ буланд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 оны эхний хагас жилийн байдлаар 2 удаа пост, мэдээ оруулсан байна.</p> <div data-bbox="1137 730 1541 1018" data-label="Image"> </div> <div data-bbox="1585 730 1989 1018" data-label="Image"> </div>
<p>1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэх;</p> <p>Шалгуур үзүүлэлт: Хоёроос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; - Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л</p>	<p>Жилдээ</p>	<p>Байгууллагын албан хаагчдад төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод, хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх, нийтийн албан тушаалтны ёс зүйг сахих, авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах чиглэлээр зөвлөмж өгч, гарын авлага тараан, Авлигыг мэдээлэх утасны дугаар бүхий суурьтай, балыг албан хаагч бүрийн ширээнд байршуулсан.</p> <p>21 аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар өөрсдийн нөөц бололцоогоор гарын авлага, тараах материалыг хэвлүүлэн орон нутгийн иргэдэд сурталчлах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>

<p>боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; - Авлигыг мэдээлэх утас 110 дугаарыг дурдсан байх</p>		
---	--	--

2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах

<p>2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах;</p> <p>Шалгуур үзүүлэлт: - Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо</p>	<p>Жилдээ</p>	<p>2024 оны эхний хагас жилд шинээр томилогдсон 6 албан хаагчид авлигын эсрэг авлигын эсрэг үйл ажиллагааны талаар болон уншиж судлах шаардлагатай хууль, тогтоомжийн жагсаалтыг албаны цахим хаягаар нь хүргүүлж мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Шинээр томилогдсон албан хаагчдыг сургалтад хамруулах саналаа АТГ-т хүргүүлсэн.</p>
<p>2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчилах арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>Шалгуур үзүүлэлт: - Хоёроос доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байх</p>		<p>Хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд салбарын хөгжлийг дэмжих, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, газар зохион байгуулалт, газрын кадастр, газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлуудыг хийж гүйцэтгэх арга зүй, норм, стандартуудыг боловсруулах, сайжруулах, албан хаагчдын ёс зүй, хандлагын талаар сургалт зохион байгуулахаар төлөвлөн, сургалтын төлөвлөгөөнд тусгасан ажлуудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Тус байгууллагаас санаачлан зохион байгуулж буй “Хариуцлагатай газрын харилцаа” аяны хүрээнд үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар “Нийслэлийн сууц өмчлөгчдийн холбоо”-той хамтран нийт-45 Сууц өмчлөгчдийн холбооны дарга, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтыг “Газрын харилцааны цахим шилжилт”, Салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилт, Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажил сэдвүүдээр зохион байгуулж, мэдээлэл өгсөн. Мөн 9 дүүргийн газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч 769 иргэн, 34 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгуулж байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилт, газрын харилцааны цахим шилжилт, албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэхэд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн. Газрын даргын 2023 оны А/37 дугаар тушаалаар “Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, 2021 оны А/04 дүгээр тушаалаар “Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/176 дугаар</p>

тушаалаар “Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, Газрын даргын 2024 оны А/177 дугаар тушаалаар тус газрын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан. Эдгээр зөвлөлд гишүүнээр томилогдон ажиллаж буй Их, дээд сургуулийн багш нар, эрдэмтэн, судлаачдад салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэл өгч, сурталчлан ажиллаж байна.



2.3. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах;

Шалгуур үзүүлэлт: - Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо

Жилдээ


Агентлагийн албан хаагчдад авлигын эсрэг хууль, тогтоомж, гарын авлагыг тараан, өрөө бүрт Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан “Нэгдье” зурагт хуудсыг байршуулж урьдчилан сэргийлэх сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Тус байгууллагас аймгуудын ГХБХБГ-т өгсөн чиглэлийн дагуу 21 аймгийн Газрын удирдлагын хэлтсээс “Авлигын эсрэг хуулийн танилцуулга, соён гэгээрүүлэх” сургалтыг сумдын газрын даамлыг хамруулан цахимаар зохион байгуулсан.

3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох

<p>3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p> <p>Шалгуур үзүүлэлт: -Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; - Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх</p>	<p>Жилдээ</p>	<p>Тус агентлагийн албан хаагчдаас болон бусад холбогдох байгууллагаас боловсруулсан гэрээний төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу нэн даруй мэдэгдэх талаар тусган холбогдох албан тушаалтнуудаар батлуулан ажиллаж байна. Тус агентлагийн албан хаагчдаас болон бусад холбогдох байгууллагаас боловсруулсан гэрээний төслийг хянан эрх зүйн үндэслэлийг хангуулан санал өгч, хяналт тавин ажилласан. Тус агентлагт 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт-173 иргэн, хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Гэрээний авлигатай холбоотой заалтыг тухай бүр оруулж, ажилласан.</p>
<p>3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх;</p> <p>Шалгуур үзүүлэлт: -Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх</p>	<p>Жилдээ</p>	<p>Байгууллагын нээлттэй, ил тод байдлыг хангах, ёс зүй, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэхэд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах замаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох зорилгоор Засгийн газрын 2020 оны “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгуулах саналаа Газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 1/551 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>“Төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-д заасны дагуу байгууллагын олон нийтийн хяналтад хамруулах мэдээллийг доорх нийгмийн сүлжээний хаягаар нийтэд ил тод, нээлттэй мэдээлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын веб сайт (https://gazar.gov.mn)-аар нэвтрэн Хууль, эрх зүй, Хүний нөөцийн ил тод байдал, Үлй ажиллагааны ил тод байдал, Авлигатай тэмцэх үйл ажиллагаа, Жендерийн эрх тэгш байдлыг хангах, Санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн данс, Тендэр гэсэн цэсүүдэд олон нийтэд ил тод, нээлттэйгээр байршуулсан. • Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын олон нийтийн цахим сүлжээ (https://www.facebook.com/gazar.gov.mn?mibextid=LQQJ4d)-нд байгууллагын санаачлан зохион байгуулж буй үйл ажиллагаа, арга хэмжээ, цаг үеийн мэдээ, мэдээлэл, албан хаагчдыг чадавхжуулах сургалтын мэдээлэл, олон нийтэд зориулсан мэдээ, мэдээллийг тухай бүр оруулж байна.

• Багууллагын веб сайтын Шилэн данс цахим хуудас <https://shilendans.gov.mn/organization/4805?ry=2024/>-нд Төсөв гүйцэтгэл цэст-17, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт цэст-6, Бусад цэст-7 аудитын тайлан дүгнэлт, хяналт шалгалтын дүн, орон тоонд орсон өөрчлөлт, байгууллагын батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн ерөнхий мэдээлэл, шийдвэр, мэдэгдэл зэрэг мэдээллийг хуулийн хугацаанд оруулан, нээлттэй мэдээлж байна.




4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах

4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ Шалгуур үзүүлэлт: - Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; Тайланд нотломжийг хавсаргасан байх

Жилдээ

Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах, хүнээс хамаарах хамаарлыг багасгах үүднээс Газрын нэгдмэл сангийн цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлэхээр Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол гарсан. Мөн Газрын тухай хуульд 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, газар олгох бүртгэх, төлбөр, татвар ногдуулах үйл ажиллагааг цахим системээр дамжуулан хэрэгжүүлж байна. Мөн Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8, 29.9 дэх хэсэгт 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр МУ-ын иргэнд гэр бүлийн хэрэгцээнд газар эзэмшүүлэх хүсэлтийг цахим системээр авч, эрэмбэлэн шийдвэрлэхээр тусгасан. Газрын мониторингийн цахим системд тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэсэн хянан баталагааны ажлын хөрс шинжилгээний хариуг цахим системд оруулах ажлыг Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораториуд оруулах ажлыг хийж гүйцэтгэн 2024.06.01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлээд байна. Засгийн газрын “Шилэн ажиллагаа”-ны хүрээнд иргэн, аж ахуй нэгж, байгууллагад олгосон газрын захирамжийг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх дэшбоардыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулан egazar.gov.mn-д

байршуулсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 114 газрын дуудлага худалдааг зохион байгуулсан. Нийт зохион байгуулагдсан дуудлага худалдааны 112 нь цахим хэлбэрээр, 2 нь танхимаар зохион байгуулагдсан. Дуудлага худалдаанд нийт 291 иргэн, хуулийн этгээд оролцож, 2.2 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлээд байна. 2024 оны хагас жилийн байдлаар нийт 56 газрын газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан. Үүнээс 54 нь Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд өрнүүлж байгаа малчдын “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн газар эзэмших төсөл сонгон шалгаруулалт эзэлж байна. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээс нийт 11 үйлчилгээг шинэчлэн засварлаж Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-д гарган хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн тайлант хугацаанд дээрх платформд шинээр 1 үйлчилгээг нэмж нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/ шинэчлэгдэж байгаатай холбоотой 30 үйлчилгээг нэвтрүүлэх боломжийн талаарх судалгааны ажилд хамтран оролцсон. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 100 дугаар тогтоолын дагуу жагсаалтад орсон 30 үйлчилгээнээс 29 үйлчилгээг www.operator.e-mongolia.mn цахим системээс, 1 үйлчилгээг www.egazar.gov.mn цахим системээс авах боломжтой болгосон. Улсын хэмжээнд шинээр газар эзэмших хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах ажлын хүрээнд цахим хүсэлт хүлээн авах холбоосыг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-д байршуулах ажлыг И-Монголиа академи УТҮГ-тай хамтран зохион байгуулж, хэрэглээнд гаргасан.



4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгах;
Шалгуур үзүүлэлт: - 2-оос доошгүйг зохион байгуулсан байх;

Жилдээ Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн “Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ” зорилтын хүрээнд Авлигатай тэмцэх газартай хамтран 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр ГЗБГЗЗЕГ-ын нэгжийн дарга нар, ахлах мэргэжилтнүүд, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга нар, 21 аймгийн ГХБХБГ-ын дарга нарыг хамруулан зохион байгуулсан. Тус сургалтаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар мэдээлэл өгч авлигаас ангид шударга, хариуцлагатай

-Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; Тайланд нотломжийг хавсаргасан байх

төрийн албыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, салбарын авлигын эсрэг хэрэгжүүлэх хамтын ажиллагаанд бодитой үр дүн гаргах, Авлигын эсрэг хууль, түүний хэрэгжилтэд анхаарах асуудал, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030”, “Авлигын эсрэг гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн зохицуулалт” зэрэг сэдвүүдээр Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх албаны дарга, эрхэлсэн комиссор Л.Сүх-Очир, Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч н.Батсайхан нар танилцуулга хийж, мэдээлэл өгсөн.



4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах;

Шалгуур үзүүлэлт: - Бодитой үр дүнг тооцсон байх;
-Тайланд нотломжийг хавсаргасан байх

Жилдээ

АТГ-аас жил бүр хийдэг “Төрийн байгууллагын шударга байдлын талаар иргэд, олон нийт, үйлчлүүлэгчдээс авсан судалгааны тайлан”-д дурдсан санал асуулгын үр дүнг шинжлэн судлахад иргэд, үйлчлүүлэгчид албан хаагчидтай биечлэн уулзах нь авлигын эрсдлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байгаа нь тодорхойлогдсон. Иймд авлигын эрсдлийг бууруулах чиглэлээр төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай хүртээмжтэй болгоход анхаарч иргэний газар эзэмших эрхийг цахим системээр гаргах эрх зүйн орчин болон цахим системийн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэн, хэрэглээнд нэвтрүүлээд байна. ЗГ-аас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”, агентлагын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жил болгон зарласантай холбогдуулан 21 аймгийн ГБХБХБГ болон НГЗБ-ны холбогдох албан хаагчдыг чадавхижуулах сургалтыг Төвийн бүст 2023.12.04-07-ны өдрүүдэд, баруун бүст 2024.01.28-02.02-ний өдрүүдэд,

говийн бүст 2024.04.09-12-ны өдрүүдэд, зүүн бүст 2024.05.14-17-ны өдрүүдэд тус тус бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтаар салбарын хууль тогтоомж, Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт, салбарын бодлого, цахим системийн үйл ажиллагааны шинэчлэлт, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр танилцуулга хийж, мэдээ мэдээлэл хүргэсэн.





5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх

5.1. Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;

Шалгуур үзүүлэлт: - Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;

Жилдээ

Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг шинээр боловсруулж, газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний төслийг “Байгууллагын удирдлагын систем”-ийн олон нийтэд байршуулан албан хаагчдаас санал авсан бөгөөд, батлагдсан төлөвлөгөөг мөн системд байршуулан хэрэгжилтийг хангах ажиллаж байна. Батлагдсан төлөвлөгөөг албан хаагчдад танилцуулсан бөгөөд эхний хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сард багтаан нийт албан хаагчдад танилцуулахаар төлөвлөсөн.

<p>5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган ажиллах;</p> <p>Шалгуур үзүүлэлт: - Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Жилдээ</p>	<p>Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор “Газар зохион байгуулалт хийх журам”, “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”, Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/180 дугаар тушаалаар “Нийтийн сервитут тогтооход нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг тогтоох, нөхөх олговрыг дүйцүүлэн тооцох журам”-ууд батлагдсан. Дээрх журмуудын нэмэлт, өөрчлөлтийн төслийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж санал авсан. Батлагдсан журмууд эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдсэн. Байгууллагын цахим хуудас шинэчлэгдэхэд хууль эрх зүй буланд “Хууль, эрх зүйн баримт бичгийн төсөлд санал авах” дэд булан байршуулсан. Мөн шинээр боловсруулж буй дүрэм, журмын төслүүдийг байгууллагын цахим хуудаст 30-аас дээш хоног байршуулж, иргэд олон нийтээс санал авч байна. жишээ нь: Засгийн газрын тогтоолоор батлагдах Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журмын төслийг 2024.04.09-ний өдөр, Мэдээллийн сангаас үзүүлэх үйчилгээ, лавлагаа, мэдээллийн авах үйлчилгээний хөлсний хэмжээний төслийг 2024.04.12-ны өдөр, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын төслийг 2024.04.09-ний өдөр тус тус байршуулж иргэд олон нийтээс санал авч байна.</p>  
<p>5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах;</p> <p>Шалгуур үзүүлэлт: - Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; - khutulbur.iaac.mn цахим санд нэмж оруулсан байх,- тайлагнасан байх.</p>	<p>Жилдээ</p>	<p>Тус газрыг МУ-ын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулахтай холбогдуулан Монгол Улсын засгийн газрын тухай хууль, Газрын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Кадастрын зураглал болон газрын кадастрын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж батлагдсан. Газрын тухай хууль болон бусад хуульд орсон өөрчлөлтөөр дараах асуудлууд туссан. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газартай холбоотой маргааныг нийслэлийн маргаан таслах зөвлөл шийдвэрлэнэ. Улсын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар дээр нийтийн болон хувийн сервитут тогтоох, Газар эзэмших эрх шилжих, хугацаа сунгах шийдвэрийг Нийслэл, дүүргийн Газрын алба гаргаж, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх боломж нээгдсэн. Монгол Улсын иргэн гэр бүлийн хэрэгцээний газрыг эзэмших хүсэлтээ цахим системээр гаргаж, цахим систем эрэмбэлэн газар олгох үйл ажиллагааг хүртээмтэй шуурхай хэрэгжүүлэх боломжтой болсон.</p>

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө” боловсруулан батлуулсан. Уг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөнд 11 арга хэмжээ тусгагдснаас 2024 оны эхний хагас жилийн байдлаар 6 арга хэмжээг хэрэгжүүлж, 54.5%-тай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэлтэд Авлигатай тэмцэх газартай хамтран хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр Авлигатай тэмцэх газрын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 03/10172 дугаартай албан бичиг хүргүүлсэн.

БЯАНЫ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАГТА

А.С. ОЮУН ПИЯ

2024 оны 06 дугаар сарын 15

БЯАНЫ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮРДЧИЛЭН
СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ
ХЭЛТЭСНИЙ ДАГТА

Х.ХИМБЭРӨН

2024 оны 06 дугаар сарын 15

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрээ түвшин, үр дүн	Хариуцах нэгж, албан хаагч
1	Төрийн ажилгаваны мэдээллийг цахимжуулах нэртэй нөхцөл мэдээлэх	Байгууллагын цахим хуудал цахимчилж үйл ажиллагааг цахим хуудал дээр иргэд оролцож мэдээлж байдал шалгах	2024.05.05	Газар зориулалт, шалгах зорилт иргэдийн талаар мэдээллийг цахим хуудал дээр цахим хуудалт нээлттэй болгосон байна.	ГЗБГЗБЭГ-Кадистрын хэлтэс
1	Төрийн ажилгаваны мэдээллийг цахимжуулах нэртэй нөхцөл мэдээлэх	Байгууллагын цахим хуудал цахимчилж үйл ажиллагааг цахим хуудал дээр иргэд оролцож мэдээлж байдал шалгах	2024.05.30	Байгууллагын цахим хуудал цахимчилж үйл ажиллагааг цахим хуудалт нээлттэй болгосон байна.	ГЗБГЗБЭГ-Мэдээлэл технологийн хэлтэс
1	Төрийн ажилгаваны мэдээллийг цахимжуулах нэртэй нөхцөл мэдээлэх	Байгууллагын цахим хуудал цахимчилж үйл ажиллагааг цахим хуудал дээр иргэд оролцож мэдээлж байдал шалгах	2024.05.30	Хуудал цахим ажилгаваны цахим хуудал дээр цахим хуудалт нээлттэй болгосон байна.	ГЗБГЗБЭГ-Орон зайн технологийн хэлтэс
2	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас төрийн албан хаагчид авлига болон зөрчил	Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэлтэд	2024.06.15	Дүн шинжилгээг зөв хийж, хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр	АТГ-Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс